

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр: А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг 97120
Утас/факс: 7038-3293 | Цахим шуудан: khovsgol@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.24 № 01/84
гэний _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.МӨНХБОЛД ТАНАА**

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нийт төсвийн хөрөнгөөр 48,036.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил худалдан авч, Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй 14,242,363.1 мянган төгрөгийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг шилжүүлэн хүлээн авч байгууллагын үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой зөрчилтэй асуудал илрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Мөрөн сумын Засаг даргаар 5 зорилт, 55 арга хэмжээтэй батлуулж, 99.4 хувийн үнэлгээтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	276,313,928.62	1,163,248,203.15
33	1.1.3 АВЛАГА	41,283,403.37	139,639,116.9
33100	1.1.3.01 Ажиллагчидтай холбогдсон авлага	490,000	0.0
33300	1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага	40,793,403.37	18,801,199.4
33500	1.1.3.07 Бусад авлага	0.0	120,837,917.5
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	0.0	120,837,917.5
34	1.1.4 УРЬДЧИЛГАА	580,000	760,000
34710	1.1.4.07 Урьдчилгаа тооцоо	580,000	760,000
34713	1.1.4.07.03 Цалингийн урьдчилгаа	580,000	760,000
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	234,450,525.25	1,022,849,086.25
35100	1.1.5.01 Түүхий эд материал	26,190,810	23,908,150
35110	1.1.5.01.01 Тусгай зориулалттай материал	26,190,810	23,908,150
35400	1.1.5.04 Хангамжийн материал	208,259,715.25	979,040,936.25
35410	1.1.5.04.01 Бичиг хэргийн материал	156,600	212,600
35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	31,164,533.25	437,463,315.25
35430	1.1.5.04.03 Сэлбэг хэрэгсэл	75,000	75,000
35450	1.1.5.04.05 Барилгын засварын материал	9,940,000	39,229,000
35470	1.1.5.04.07 Бусад хангамжийн материал	166,923,582	502,061,021
35600	1.1.5.06 Мал амьтад	0.0	19,900,000
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	33,361,114,626.25	40,344,318,002.66
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,361,114,626.25	40,344,318,002.66
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	22,718,479,876.21	28,521,546,990.74
39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	3,182,205,600.21	7,994,056,246.03
39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	-346,546,774.7	-1,181,900,482.57
39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	145,399,999	2,024,793,924
39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	-26,754,999.59	-897,223,395.27
39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	644,295,607.8	905,338,008.73
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	-305,743,624.84	-258,510,454.23
39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	193,809,105	204,283,105
39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	-37,012,696.92	-57,278,874.04
39209	1.2.2.02.09 Зам, гүүрийн байгууламж	17,630,871,069.11	19,917,191,856.11
39210	1.2.2.02.10 Хуримтлагдсан элэгдэл	-6,707,179,203.23	-8,147,952,531.83
39214	1.2.2.02.14 Бусад үндсэн хөрөнгө	11,761,295,359.37	12,856,632,855.33

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

39215	1.2.2.02.15 Хуримтлагдсан элэгдэл	-3,987,832,425	-5,409,818,126.52
39217	1.2.2.02.17 Ном	571,672,860	571,934,860
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	10,642,634,750.04	11,822,771,011.92
39301	1.2.2.03.01 Програм хангамж	283,750	11,808,750
39302	1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл	0.0	-7,287,183.16
39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	10,644,251,000	11,822,049,445
39304	1.2.2.03.04 Хуримтлагдсан элэгдэл	-1,899,999.96	-3,799,999.92
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	33,637,428,554.87	41,507,566,205.81
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	608,656	149,810,323
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	608,656	149,810,323
41300	2.1.1.03 Өглөг	608,656	149,810,323
41310	2.1.1.03.01 Ажилчидтай холбогдсон өглөг	219,700	0.0
41320	2.1.1.03.02 Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	2,735,217
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	388,956	147,075,106
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	388,956	98,519,880
41362	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	48,555,226
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,636,819,898.87	41,357,755,882.81
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	33,636,819,898.87	41,357,755,882.81
51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	11,668,053,898.45	11,668,053,898.45
511002	2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	11,668,053,898.45	11,668,053,898.45
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	21,592,475,271.75	29,313,411,255.69
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	18,551,476,621.11	21,592,475,271.75
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	3,040,998,650.64	7,720,935,983.94
51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,290,728.67	376,290,728.67
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	33,637,428,554.87	41,507,566,205.81

Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	9,098,672,482.08	17,091,868,197.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,665,518,003.08	17,091,868,197.96
120	Нийтлэг татварын бус орлого	5,658,205,503.08	12,398,419,776.33
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,658,205,503.08	12,398,419,776.33
122	Тусламжийн орлого	7,312,500.00	4,693,448,421.63
1221	Хандив тусламж /дотоод/	7,312,500.00	4,693,448,421.63
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,544,416,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	4,544,416,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	149,031,821.63

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,950,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	92,138,735.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	53,943,086.63
122001	Бусад хандив тусламж /дотоод/	7,312,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,433,154,479.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,780,979.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,935,429.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,845,550.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,275,373,500.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,275,373,500.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,890,308,665.20	8,202,440,518.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,890,308,665.20	8,202,440,518.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,720,785,886.65	7,831,582,232.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,492,508,521.75	1,867,972,031.30
210101	Үндсэн цалин	704,658,793.29	921,515,116.09
210102	Нэмэгдэл	696,147,810.84	836,812,577.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,002,997.62	109,644,338.08
210104	Урамшуулал	36,698,920.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,335,814.65	230,418,561.09
210201	Тэтгэврийн даатгалын зардал	127,191,069.98	158,150,562.47
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,963,654.52	18,676,166.53
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	7,717,336.19	9,487,011.72
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	6,892,750.21	9,077,565.97
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	27,571,003.75	35,027,254.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,333,390.23	232,850,393.76
210301	Гэрэл, цахилгаан	12,263,793.49	30,845,441.43
210302	Түлш, халаалт	132,620,350.58	192,344,560.39
210303	Цэвэр, бохир ус	17,449,246.16	9,660,391.94
2104	Хангамж, бараа материалын зардал	57,698,560.95	74,563,514.60
210401	Бичиг хэрэг	18,498,710.00	23,723,760.00
210402	Тээвэр, шатахуун	21,369,050.00	27,898,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,630,711.95	11,865,547.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,200,089.00	11,075,797.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,959,000.00	49,380,740.00
210604	Урсгал засвар	51,959,000.00	49,380,740.00
2107	Томилолт, зочны зардал	24,113,242.65	22,226,738.00
210702	Дотоод албан томилолт	15,625,600.00	19,071,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,487,642.65	3,155,738.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,107,297,302.22	1,369,193,855.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,102,997,434.22	1,366,952,095.94
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,468.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	105,060.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,964,000.00	1,836,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,640,540,054.20	3,984,976,397.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,153,754.00	284,145,051.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,554,000.00	3,285,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,537,832,300.20	3,697,546,346.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,522,778.55	370,858,286.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	262,790,536.41
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	262,790,536.41
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	262,790,536.41
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	262,790,536.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,855,469.59	108,067,750.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	54,735,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	85,855,469.59	53,332,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	83,667,308.96	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,667,308.96	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,208,363,816.88	8,889,427,679.47
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	167,365,166.24	1,168,491,695.53
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	115,357,258.24	1,109,415,765.53
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	52,007,908.00	59,075,930.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(167,365,166.24)	(1,168,491,695.53)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	3,040,998,650.64	7,720,935,983.94

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,464,561,602.37	4,734,241,825.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,734,241,825.00
122	Тусламжийн орлого	-	4,734,241,825.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	4,734,241,825.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	4,544,416,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	4,544,416,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	189,825,225.00
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,950,000.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	92,138,735.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	94,736,490.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,464,561,602.37	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,188,102.37	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,312,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,935,429.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,940,173.37	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,275,373,500.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,275,373,500.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,379,545,102.37	4,687,126,525.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,379,545,102.37	4,687,126,525.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,169,228,920.45	4,307,465,039.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,492,508,521.75	1,867,972,031.30
210101	Үндсэн цалин	704,658,793.29	921,515,116.09
210102	Нэмэгдэл	696,147,810.84	836,812,577.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,002,997.62	109,644,338.08
210104	Урамшуулал	36,698,920.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,335,814.65	230,418,561.09
210201	Тэтгэврийн даатгалын зардал	127,191,069.98	158,150,562.47
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	14,963,654.52	18,676,166.53
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	7,717,336.19	9,487,011.72
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	6,892,750.21	9,077,565.97
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	27,571,003.75	35,027,254.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,333,390.23	233,023,891.26
210301	Гэрэл, цахилгаан	12,263,793.49	31,446,013.93
210302	Түлш, халаалт	132,620,350.58	192,344,560.39
210303	Цэвэр, бохир ус	17,449,246.16	9,233,316.94
2104	Хангамж, бараа материалын зардал	55,298,965.95	60,011,802.09
210401	Бичиг хэрэг	17,033,129.00	17,714,740.00
210402	Тээвэр, шатахуун	21,368,055.00	24,818,649.49
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,897,792.95	10,207,475.60

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,999,989.00	7,270,937.00
2105	Нормативт зардал	-	1,270,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,270,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,660,850.00	29,376,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	-
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	52,660,850.00	29,376,990.00
2107	Томилолт, зочны зардал	24,603,242.65	15,326,738.00
210702	Дотоод албан томилолт	16,115,600.00	12,171,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,487,642.65	3,155,738.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,092,094,975.22	1,549,438,774.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,087,795,107.22	1,545,252,014.45
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,468.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	105,060.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,964,000.00	3,781,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,393,160.00	320,626,251.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,839,160.00	317,341,251.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,554,000.00	3,285,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,316,181.92	379,661,485.81
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	281,591,735.81
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	281,591,735.81
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	281,591,735.81
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	262,790,536.41
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	18,801,199.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,855,469.59	98,069,750.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	54,735,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	85,855,469.59	43,334,050.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	124,460,712.33	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,667,308.96	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	40,793,403.37	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	85,016,500.00	47,115,300.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	85,016,500.00	47,115,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,016,500.00	47,115,300.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	85,016,500.00	47,115,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,016,500.00	47,115,300.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(85,016,500.00)	(47,115,300.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
		1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	18,551,476,621.11	30,595,821,248.23
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	18,551,476,621.11	30,595,821,248.23
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	3,040,998,650.64	3,040,998,650.64
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	21,592,475,271.75	33,636,819,898.87
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	21,592,475,271.75	33,636,819,898.87
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	21,592,475,271.75	33,636,819,898.87
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	7,720,935,983.94	7,720,935,983.94
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,668,053,898.45	376,290,728.67	29,313,411,255.69	41,357,755,882.81

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,729,589,800.00	4,281,626,063.59	447,963,736.41	90.5
12	Татварын бус орлого	4,729,589,800.00	4,281,626,063.59	447,963,736.41	90.5
122	Тусламжийн орлого	4,729,589,800.00	4,281,626,063.59	447,963,736.41	90.5
122005	Төсвөөс санхүүжих	4,729,589,800.00	4,281,626,063.59	447,963,736.41	90.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,729,589,800.00	4,281,626,063.59	447,963,736.41	90.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,729,589,800.00	4,281,626,063.59	447,963,736.41	90.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,625,636,800.00	4,185,556,313.59	440,080,486.41	90.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,928,613,700.00	1,867,972,031.30	60,641,668.70	96.9
210101	Үндсэн цалин	1,125,054,600.00	921,515,116.09	203,539,483.91	81.9
210102	Нэмэгдэл	675,751,100.00	836,812,577.13	(161,061,477.13)	123.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	127,808,000.00	109,644,338.08	18,163,661.92	85.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,076,800.00	230,418,561.09	10,658,238.91	95.6
210201	Тэтгэврийн даатгал	163,932,300.00	158,150,562.47	5,781,737.53	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	19,286,200.00	18,676,166.53	610,033.47	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,643,000.00	9,487,011.72	155,988.28	98.4
210204	Ажилгүйдлийн даатгал	9,643,000.00	9,077,565.97	565,434.03	94.1
210205	Эрүүл мэндийн даатгал	38,572,300.00	35,027,254.40	3,545,045.60	90.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,400,000.00	225,955,641.26	4,444,358.74	98.1
210301	Гэрэл, цахилгаан	22,400,000.00	24,377,763.93	(1,977,763.93)	108.8
210302	Түлш, халаалт	197,000,000.00	192,344,560.39	4,655,439.61	97.6
210303	Цэвэр, бохир ус	11,000,000.00	9,233,316.94	1,766,683.06	83.9
2104	Хангамж, бараа материалын зардал	54,965,700.00	38,889,178.09	16,076,521.91	70.8
210401	Бичиг хэрэг	17,125,700.00	13,182,360.00	3,943,340.00	77.0
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00	8,648,405.49	6,351,594.51	57.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,840,000.00	9,787,475.60	1,052,524.40	90.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,000,000.00	7,270,937.00	4,729,063.00	60.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,000,000.00	32,237,750.00	6,762,250.00	82.7
210602	Тавилга	19,000,000.00	17,493,300.00	1,506,700.00	92.1
210604	Урсгал засвар	20,000,000.00	14,744,450.00	5,255,550.00	73.7

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	30,000,000.00	15,326,738.00	14,673,262.00	51.1
210702	Дотоод албан томилолт	20,000,000.00	12,171,000.00	7,829,000.00	60.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,000,000.00	3,155,738.00	6,844,262.00	31.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,788,692,600.00	1,477,883,162.85	310,809,437.15	82.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,781,972,600.00	1,473,696,402.85	308,276,197.15	82.7
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	-	300,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	105,060.00	14,940.00	87.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000,000.00	3,781,700.00	2,218,300.00	63.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	312,888,000.00	296,873,251.00	16,014,749.00	94.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	305,000,000.00	293,466,251.00	11,533,749.00	96.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,888,000.00	3,407,000.00	4,481,000.00	43.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,953,000.00	96,069,750.00	7,883,250.00	92.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,953,000.00	96,069,750.00	7,883,250.00	92.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,735,700.00	54,735,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,217,300.00	41,334,050.00	7,883,250.00	84.0

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	189,825,225.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	189,825,225.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	189,825,225.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	189,825,225.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	189,825,225.00
350011	1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,950,000.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,138,735.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	94,736,490.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	189,825,225.00

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	189,825,225.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,024,025.60
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,068,250.00
210301	1.1.1.2.1.1.3.1 Гэрэл, цахилгаан	7,068,250.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	21,122,624.00
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	4,532,380.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	16,170,244.00
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	420,000.00
2105	1.1.1.2.1.1.5 Нормативт зардал	1,270,000.00
210503	1.1.1.2.1.1.5.3 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,270,000.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	14,632,540.00
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	14,632,540.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,055,611.60
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,055,611.60
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	23,875,000.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	23,875,000.00
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлэг	18,801,199.40

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн худалдан авах ажиллагаатай холбоотой 126,925.0 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 120,237.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулан бүртгэсэн. Үүнд:

- Мөрөн сумын Засаг даргын 2025.11.24-ны өдрийн захирамжаар Бүтээлч Мөрөнчүүд үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан төсөв зарцуулах захирамжийг гаргасан бөгөөд Мөрөн сумын Засаг дарга нь Хөдөөгийн шийдэл ХХК-тай гэрээ байгуулан үндсэн үнийн 50 хувиар тооцож 186,580.4 мянган төгрөгийн үнэтэй 68 ширхэг хүлэмжүүдийг худалдан авч иргэдэд 43 ширхэг 120,237.9 мянган төгрөгийн хүлэмжийг олгохдоо авлага үүсгээгүй байсныг авлага үүсгэж залруулсан.

Аудитаар илрүүлсэн 120,237.9 мянган төгрөгийн алдаа, 126,925.0 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус алдаа, зөрчил тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Шийдвэргүйгээр олгосон 1,137.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг аудитын хугацаанд Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн тул төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өнгөлөг мөрөн аяны хүрээнд Мөрөн сумын тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 126,925.0 мянган төгрөгийн урсгал засварын материалыг худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.тай нийцээгүй бөгөөд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхисон		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НББ-ийн тооцооллын алдаа	1	120,237.9	-	-	1	120,237.9	1	120,237.9	-	-
Дүн	1	120,237.9	-	-	1	120,237.9	1	120,237.9	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Нийцлийн аудиттай холбоотой зөрчил									
Худалдан авах ажиллагааны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй	1	126,925.0	-	-	-	-	1	126,925.0	
Дүн	1	126,925.0	-	-	-	-	1	126,925.0	